ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

---

Говь-Алтай аймгийн Прокурорын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

**Аудитын код:** ГАА-2022/61/-НА-СТА-ТШЗ


| | | |
|---|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Алтай хот<br>2022 он | Дарга, Тэргүүлэх аудитор: | Х.Түвшинбаяр |
| | Утас: 70483413 | Цахим хаяг: tuvshinbayarkh@audit.gov.mn |
| | Аудитын менежер: | Д.Эрдэнэчимэг |
| | Утас: 70484055 | Цахим хаяг: erdenechimegd@audit.gov.mn |
| | Ахлах аудитор: | Ж.Бүжинханд |
| | Утас: 99177546 | Цахим хаяг: Bujinkhandj@audit.gov.mn |
| | Аудитор: | С.Санчирмаа |
| | Утас:99282488 | Цахим хаяг: Sanchirmaas@audit.gov.mn |


Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга


1. Аудитын санал дүгнэлт ........ 2
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл ........ 4
3. Аудитын тайлан ........ 9
   3.1 Ерөнхий зүйл ........ 9
   3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт ........ 10
   3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал ........ 10
   3.4 Материаллаг байдал ........ 10
   3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга ........ 10
   3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв ........ 11
   3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг ........ 11
   3.8 Аудитын гол асуудал ........ 11
   3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал ........ 12
   3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт ........ 12
   3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал ........ 12
4. Аудитын илрүүлэлт ........ 13
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл ........ 13


**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар |

Говь-Алтай аймаг дахь ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

**ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

9018301, Говь-Алтай аймаг,
Есөнбулаг сум, 7-р баг, Жинст 0
Утас: 70-48-34-13. Факс: (976) 70-48-34-13,
E –mail: govialtai@audit.gov.mn

2022.02.23 № 09

танай ____________ -ны №____________ -т

ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН ПРОКУРОРЫН ГАЗРЫН ЕРӨНХИЙ ПРОКУРОР ХУУЛЬ ЦААЗЫН ШАДАР ЗӨВЛӨХ Б.БИЛЭГСАЙХАН ТАНАА

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны Прокурорын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Прокурорын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх

07920076

үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Х.ТҮВШИНБАЯР

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

| Код | Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| 1 | ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | 21,054,197.54 | 28,624,424.00 |
| 33 | АВЛАГА | 1,191,473.54 | - |
| 33100 | Ажиллагчидтай холбогдсон авлага | 249,534.74 | - |
| 33500 | Бусад авлага | 941,938.80 | - |
| 33510 | Байгууллагаас авах авлага | 941,938.80 | - |
| 35 | БАРАА МАТЕРИАЛ | 19,862,724.00 | 28,624,424.00 |
| 35400 | Хангамжийн материал | 19,862,724.00 | 28,624,424.00 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 3,839,833.00 | 5,433,733.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 769,900.00 | 832,550.00 |
| 35430 | Сэлбэг хэрэгсэл | 48,000.00 | 48,000.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 15,204,991.00 | 22,310,141.00 |
| 2 | ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | 608,732,200.69 | 621,325,116.29 |
| 39 | ҮНДСЭН ХӨРӨНГӨ | 608,732,200.69 | 621,325,116.29 |
| 39200 | Биет хөрөнгө | 572,596,200.69 | 585,189,116.29 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 508,384,169.00 | 508,384,169.00 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (32,480,986.68) | (49,210,368.68) |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 121,700,000.00 | 121,700,000.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | (78,361,111.08) | (87,327,777.72) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж(компьютер) | 63,085,446.04 | 101,742,900.71 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (29,460,799.97) | (40,428,808.67) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 46,529,643.33 | 64,371,643.33 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (26,800,159.95) | (34,042,641.68) |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 800,000.00 | 800,000.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | (800,000.00) | (800,000.00) |
| 39300 | Биет бус хөрөнгө | 36,136,000.00 | 36,136,000.00 |
| 39301 | Програм хангамж | 785,000.00 | 785,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (785,000.00) | (785,000.00) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 36,136,000.00 | 36,136,000.00 |
| 3 | НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II | 629,786,398.23 | 649,949,540.29 |
| 4 | НИЙТ ӨР ТӨЛБӨР | 249,534.74 | - |
| 41 | БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР | 249,534.74 | - |
| 41300 | Өглөг | 249,534.74 | - |
| 41360 | Бусад өглөг | 249,534.74 | - |
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | 249,534.74 | - |
| 5 | ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН | 629,536,863.49 | 649,949,540.29 |
| 51 | Засгийн газрын хувь оролцоо | 629,536,863.49 | 649,949,540.29 |
| 51100 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 514,337,615.75 | 514,337,615.75 |
| 51200 | Хуримтлагдсан үр дүн | (27,005,540.82) | (6,592,864.02) |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | (27,049,899.76) | (27,005,540.82) |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 44,358.94 | 20,412,676.80 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 142,204,788.56 | 142,204,788.56 |
| 6 | ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V | 629,786,398.23 | 649,949,540.29 |

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

| Код | Үзүүлэлт | ӨМНӨХ ОН | ТАЙЛАНТ ОН |
|---|---|---|---|
| **I** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | 446,327,766.29 | 584,470,888.00 |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | 16,167,366.29 | 28,619,488.00 |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 16,167,366.29 | 28,619,488.00 |
| 120017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө | 16,167,366.29 | 25,640,488.00 |



Говь-Алтай аймаг дахь ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

| | | | |
|---|---|---|---|
| 120018 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал | - | 2,979,000.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | 430,160,400.00 | 555,851,400.00 |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 425,160,400.00 | 550,851,400.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 425,160,400.00 | 550,851,400.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 5,000,000.00 | 5,000,000.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 5,000,000.00 | 5,000,000.00 |
| **II** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | 446,283,407.35 | 564,058,211.20 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 446,283,407.35 | 564,058,211.20 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 409,512,545.57 | 529,547,146.12 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 281,915,824.00 | 346,542,945.28 |
| 210101 | Үндсэн цалин | 208,384,900.00 | 218,929,578.09 |
| 210102 | Нэмэгдэл | 67,306,924.00 | 109,588,370.20 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 6,224,000.00 | 18,024,996.99 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 35,035,465.22 | 43,823,915.02 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 29,453,965.22 | 30,534,753.27 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | - | 3,400,213.82 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | - | 2,713,450.13 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | - | 652,318.34 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 5,581,500.00 | 6,523,179.46 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 22,086,947.00 | 24,191,589.50 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 2,169,687.00 | 1,887,313.94 |
| 210302 | Түлш, халаалт | 18,212,040.00 | 21,141,707.56 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 1,705,220.00 | 1,162,568.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 25,423,594.20 | 25,603,774.92 |
| 210401 | Бичиг хэрэг | 8,700,700.00 | 10,658,900.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 7,387,996.20 | 9,041,938.80 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,470,998.00 | 2,697,086.12 |
| 210404 | Ном, хэвлэл | 195,700.00 | 368,900.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 2,090,000.00 | 160,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 5,578,200.00 | 2,676,950.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 1,039,400.00 | 19,216,040.00 |
| 210604 | Урсгал засвар | 1,039,400.00 | 19,216,040.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 1,389,500.00 | 1,277,200.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 1,389,500.00 | 1,277,200.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 4,170,204.00 | 13,667,699.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 2,978,004.00 | 12,207,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 961,200.00 | 961,175.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 132,800.00 | 148,204.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 22,000.00 | 44,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | - | 231,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 76,200.00 | 76,320.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 38,451,611.15 | 55,223,982.40 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 2,300,000.00 | 5,271,610.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 4,850,000.00 | 5,800,000.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 31,301,611.15 | 44,152,372.40 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 36,770,861.78 | 34,511,065.08 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 31,766,000.00 | 500,000.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 25,741,000.00 | |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 6,025,000.00 | 500,000.00 |



Говь-Алтай аймаг дахь ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

| | | | |
|---|---|---|---|
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 5,004,861.78 | 34,011,065.08 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 5,004,861.78 | 34,011,065.08 |
| **III** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)** | 44,358.94 | 20,412,676.80 |
| **VI** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)** | 44,358.94 | 20,412,676.80 |

## 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

| **Үзүүлэлт** | **Засгийн газрын оруулсан капитал** | **Дахин үнэлгээний нөөц** | **Хуримтлагдсан дүн** | **Засгийн газрын хувь оролцооны нийт дүн** |
|---|---|---|---|---|
| **2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | 514,337,615.75 | 142,204,788.56 | (27,049,899.76) | 629,492,504.55 |
| Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | - | - |
| Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 514,337,615.75 | 142,204,788.56 | (27,049,899.76) | 629,492,504.55 |
| Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт | - | - | - | - |
| Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт | - | - | - | - |
| Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | - | - | - | - |
| Өмчид гарсан өөрчилөлт | - | - | - | - |
| Зарласан ногдол ашиг | - | - | - | - |
| Тайлант үеийн үр дүн | - | - | 44,358.94 | 44,358.94 |
| **2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | 514,337,615.75 | 142,204,788.56 | (27,005,540.82) | 629,536,863.49 |
| **2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | 514,337,615.75 | 142,204,788.56 | (27,005,540.82) | 629,536,863.49 |
| Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | - | - |
| **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | 514,337,615.75 | 142,204,788.56 | (27,005,540.82) | 629,536,863.49 |
| Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт | - | - | - | - |
| Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт | - | - | - | - |
| Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | - | - | - | - |
| Өмчид гарсан өөрчилөлт | - | - | - | - |
| Зарласан ногдол ашиг | - | - | - | - |
| Тайлант үеийн үр дүн | - | - | 20,412,676.80 | 20,412,676.80 |
| **2021 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл** | 514,337,615.75 | 142,204,788.56 | (6,592,864.02) | 649,949,540.29 |

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

| Код | Үзүүлэлт | ӨМНӨХ ОН | ТАЙЛАНТ ОН |
|---|---|---|---|
| I | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I) | 430,160,400.00 | 555,920,296.00 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 430,160,400.00 | 555,920,296.00 |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 425,160,400.00 | 550,851,400.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 425,160,400.00 | 550,851,400.00 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 5,000,000.00 | 5,000,000.00 |

Говь-Алтай аймаг дахь ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

| | | | |
|---|---|---|---|
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 5,000,000.00 | 5,000,000.00 |
| 1340 | Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих | - | 68,896.00 |
| 134001 | Нийгмийн даатгалын сангаас санхүүжих | - | 68,896.00 |
| II | НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 422,860,400.00 | 524,815,496.00 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 422,860,400.00 | 524,815,496.00 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 386,089,538.22 | 490,235,534.92 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 281,915,824.00 | 346,542,945.28 |
| 210101 | Үндсэн цалин | 208,384,900.00 | 218,929,578.09 |
| 210102 | Нэмэгдэл | 67,306,924.00 | 109,588,370.40 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 6,224,000.00 | 18,024,996.79 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 35,035,465.22 | 43,823,915.02 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 23,872,365.22 | 30,534,753.27 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,790,800.00 | 3,400,213.82 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,232,600.00 | 2,713,450.13 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 558,200.00 | 652,318.34 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 5,581,500.00 | 6,523,179.46 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 22,086,947.00 | 24,191,589.50 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 2,169,687.00 | 1,887,313.94 |
| 210302 | Түлш, халаалт | 18,212,040.00 | 21,141,707.56 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 1,705,220.00 | 1,162,568.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 25,276,598.00 | 26,521,286.12 |
| 210401 | Бичиг хэрэг | 10,500,000.00 | 9,711,500.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 8,200,000.00 | 8,100,000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,470,998.00 | 2,711,086.12 |
| 210404 | Ном, хэвлэл | 195,700.00 | 408,900.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 2,090,000.00 | 999,900.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 2,819,900.00 | 4,589,900.00 |
| 2105 | Нормативт зардал | 65,000.00 | - |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 65,000.00 | - |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 5,400,000.00 | 18,247,040.00 |
| 210604 | Урсгал засвар | 5,400,000.00 | 18,247,040.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 1,389,500.00 | 1,277,200.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 1,389,500.00 | 1,277,200.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 7,770,204.00 | 16,792,699.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 6,578,004.00 | 15,332,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 961,200.00 | 961,175.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 132,800.00 | 148,204.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 22,000.00 | 44,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | - | 231,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 76,200.00 | 76,320.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 7,150,000.00 | 12,838,860.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 2,300,000.00 | 6,929,060.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 4,850,000.00 | 5,909,800.00 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 36,770,861.78 | 34,579,961.08 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 31,766,000.00 | 568,896.00 |
| 213202 | Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж | - | 68,896.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 25,741,000.00 | - |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 6,025,000.00 | 500,000.00 |
| 2133 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг | 5,004,861.78 | 34,011,065.08 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 5,004,861.78 | 34,011,065.08 |
| III | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II) | 7,300,000.00 | 31,104,800.00 |
| V | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V) | 7,300,000.00 | 31,104,800.00 |
| 22 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 7,300,000.00 | 31,104,800.00 |
| 2200 | Дотоод эх үүсвэрээр | 7,300,000.00 | 31,104,800.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 7,300,000.00 | 31,104,800.00 |
| VI | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V) | (7,300,000.00) | (31,104,800.00) |
| VIII | НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII) | - | - |
| 101 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | - | - |
| 20 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | - | - |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

| Үзүүлэлт | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл | Төсвийн хэмнэлт+, хэмнэлт- | Хувь |
|---|---|---|---|---|
| НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 550,851,400.00 | 516,840,334.92 | 34,011,065.08 | 94% |
| УРСГАЛ ЗАРДАЛ | 550,851,400.00 | 516,840,334.92 | 34,011,065.08 | 94% |
| БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 550,351,400.00 | 516,340,334.92 | 34,011,065.08 | 94% |
| Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 374,679,500.00 | 346,542,945.28 | 28,136,554.72 | 92% |
| Үндсэн цалин | 238,494,500.00 | 218,929,578.09 | 19,564,921.91 | 92% |
| Нэмэгдэл | 116,599,000.00 | 109,588,370.40 | 7,010,629.60 | 94% |
| Унаа хоолны хөнгөлөлт | 19,586,000.00 | 18,024,996.79 | 1,561,003.21 | 92% |
| Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 46,734,900.00 | 43,823,915.02 | 2,910,984.98 | 94% |
| Тэтгэврийн даатгал | 32,047,200.00 | 30,534,753.27 | 1,512,446.73 | 95% |
| Тэтгэмжийн даатгал | 3,671,900.00 | 3,400,213.82 | 271,686.18 | 93% |
| ҮОМШӨ-ний даатгал | 2,937,500.00 | 2,713,450.13 | 224,049.87 | 92% |
| Ажилгүйдлийн даатгал | 734,400.00 | 652,318.34 | 82,081.66 | 89% |
| Эрүүл мэндийн даатгал | 7,343,900.00 | 6,523,179.46 | 820,720.54 | 89% |
| Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 25,118,800.00 | 24,191,589.50 | 927,210.50 | 96% |
| Гэрэл, цахилгаан | 2,516,900.00 | 1,887,313.94 | 629,586.06 | 75% |
| Түлш, халаалт | 20,829,900.00 | 21,141,707.56 | (311,807.56) | 101% |
| Цэвэр, бохир ус | 1,772,000.00 | 1,162,568.00 | 609,432.00 | 66% |
| Хангамж, бараа материалын зардал | 26,125,100.00 | 25,531,286.12 | 593,813.88 | 98% |
| Бичиг хэрэг | 9,711,500.00 | 9,711,500.00 | - | 100% |
| Тээвэр, шатахуун | 8,100,000.00 | 8,100,000.00 | - | 100% |
| Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 3,304,400.00 | 2,711,086.12 | 593,313.88 | 82% |
| Ном, хэвлэл | 409,200.00 | 408,900.00 | 300.00 | 100% |
| Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 1,000,000.00 | 999,900.00 | 100.00 | 100% |
| Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 3,600,000.00 | 3,599,900.00 | 100.00 | 100% |
| Эд хогшил, урсгал засварын зардал | 42,290,500.00 | 42,282,040.00 | 8,460.00 | 100% |
| Багаж, техник, хэрэгсэл | 10,000,000.00 | 10,000,000.00 | - | 100% |
| Тавилга | 16,000,000.00 | 15,992,000.00 | 8,000.00 | 100% |
| Урсгал засвар | 16,290,500.00 | 16,290,040.00 | 460.00 | 100% |
| Томилолт, зочны зардал | 2,709,600.00 | 1,277,200.00 | 1,432,400.00 | 47% |
| Дотоод албан томилолт | 2,709,600.00 | 1,277,200.00 | 1,432,400.00 | 47% |
| Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 16,793,000.00 | 16,792,699.00 | 301.00 | 100% |
| Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 15,332,000.00 | 15,332,000.00 | - | 100% |
| Даатгалын үйлчилгээ | 961,200.00 | 961,175.00 | 25.00 | 100% |
| Тээврийн хэрэгслийн татвар | 148,300.00 | 148,204.00 | 96.00 | 100% |
| Тээврийн хэрэгслийн оношлогоо | 44,000.00 | 44,000.00 | - | 100% |
| Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 231,000.00 | 231,000.00 | - | 100% |
| Газрын төлбөр | 76,500.00 | 76,320.00 | 180.00 | 100% |



Говь-Алтай аймаг дахь ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

| | | | | |
|---|---|---|---|---|
| Бараа үйлчилгээний бусад зардал | 15,900,000.00 | 15,898,660.00 | 1,340.00 | 100% |
| Бараа үйлчилгээний бусад зардал | 7,300,000.00 | 7,299,060.00 | 940.00 | 100% |
| Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 8,600,000.00 | 8,599,600.00 | 400.00 | 100% |
| УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 500,000.00 | 500,000.00 | - | 100% |
| Бусад урсгал шилжүүлэг | 500,000.00 | 500,000.00 | - | 100% |
| Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 500,000.00 | 500,000.00 | - | 100% |
| ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 550,851,400.00 | 516,840,334.92 | 34,011,065.08 | 94% |
| УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 550,851,400.00 | 516,840,334.92 | 34,011,065.08 | 94% |
| Улсын төсвөөс санхүүжих | 550,851,400.00 | 516,840,334.92 | 34,011,065.08 | 94% |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

| Үзүүлэлт | Тайлант оны | |
|---|---|---|
| | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл |
| НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | - | 5,000,000.0 |
| УРСГАЛ ЗАРДАЛ | - | 5,000,000.0 |
| БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | - | 5,000,000.00 |
| Хангамж, бараа материалын зардал | - | 990,000.00 |
| Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | | 990,000.00 |
| Эд хогшил, урсгал засварын зардал | - | 4,010,000.00 |
| Багаж, техник, хэрэгсэл | - | 2,053,000.00 |
| Урсгал засвар | - | 1,957,000.00 |
| ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | - | 5,000,000.0 |
| Нэмэлт санхүүжилтийн орлого | - | 5,000,000.00 |
| ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | - | 5,000,000.00 |

## 3. Аудитын тайлан

### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Говь-Алтай аймгийн Прокурорын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаатай холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор С.Санчирмаа гүйцэтгэж, хяналтыг ахлах аудитор Ж.Бужинханд, аудитын менежер Д.Эрдэнэчимэг, дарга, тэргүүлэх аудитор Х.Түвшинбаяр нар тус тус хэрэгжүүлсэн.

Говь-Алтай аймгийн Прокурорын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 21-ний өдрийн 1/93 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

Говь-Алтай аймаг дахь ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Говь-Алтай аймгийн Прокурорын газар нь "Хуулийн хэрэгжилтэд хяналт тавих, хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт, ял эдлүүлэх ажиллагаанд хяналт тавих" үйл ажиллагааны чиглэлтэй.

Тайлант хугацаанд байгууллагын санхүү, нягтлан бодох бүртгэлд төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд өөрчлөлт орсон.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Говь-Алтай аймгийн Прокурорын газрын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл бага гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 446.3 сая төгрөгөөс 2 хувиар буюу 8.9 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 7.1 сая төгрөгөөр тогтоосон.

Гүйцэтгэлийн үе шатанд 2021 оны санхүүгийн тайлангийн нийт зардлын дүн болох 564.0 сая төгрөгөөс 2 хувиар буюу 11.3 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг гүйцэтгэлийн материаллаг байдлын 80 хувиар буюу 9.0 сая төгрөгөөр тогтоогдож байна.

Аудитын эрсдэл бага гэж үзэж тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг АДБОУС 2320-н 13-д заасны дагуу аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Говь-Алтай аймгийн Прокурорын газрын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 3 хувиар буюу 20.2 сая төгрөгөөр

Говь-Алтай аймаг дахь ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан хангамжийн материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Өмнөх оны 1.2 сая төгрөгийн авлага барагдсантай холбоотой авлагын үлдэгдэлгүй.

Бараа материалын дансны үлдэгдэл 28.6 сая төгрөг болж 8.8 сая төгрөгөөр өссөн нь хангамжийн материал нэмэгдсэнтэй холбоотой. Тайлант хугацаанд төсвийн хөрөнгөөр 51.3 сая төгрөгийн бараа материал бэлтгэж, 3.0 сая төгрөгийн үнэ төлбөргүй хүлээн авч үйл ажиллагаандаа 45.5 сая төгрөгийн материалыг зарцуулжээ. Оны эцэст 28.6 сая төгрөгийн бараа материалын үлдэгдэлтэй байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 621.3 сая төгрөг болж 12.6 сая төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 31.1 сая төгрөгийн хөрөнгө бэлтгэж, 54.6 сая төгрөгийн тавилга эд хогшил, машин тоног төхөөрөмжийг үнэ төлбөргүйгээр хүлээн авсантай холбоотой.

Тайлант онд Улсын ерөнхий прокурорын газраас 25.6 сая төгрөгийн суурин болон зөөврийн компьютер, тусгай зориулалтын сейф, олон үйлдэлт хувилагч, өрөөний дохиоллын систем үнэ төлбөргүй хүлээн авсан оны эцэст 621.3 сая төгрөгийн үндсэн хөрөнгийн үлдэгдэлтэй байна.

Өр төлбөрийн дансны үлдэгдэлгүй.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 649.9 сая төгрөг болж 20.4 сая төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ. Орлого өмнөх оноос 31 хувиар буюу 138.1 сая төгрөгөөр өссөн нь санхүүжилтийн орлого, үнэ төлбөргүй хүлээн авсан хөрөнгийн орлоготой холбоотой байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар өмнөх оны үр дүн рүү хаасан бичилт хийгдээгүй ба тайлант оны хуримтлагдсан үр дүнгийн эцсийн үлдэгдэл 6.6 сая төгрөг болсон байна.

### 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 447.7 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсөв захирагчид хүргүүлсэн төсвийн төслөөс 103.1 сая төгрөгөөр өсгөж, 550.8 сая төгрөгөөр баталжээ. Төсвийн төсөл өмнөх оны батлагдсан төсвөөс их байгаа нь цалингийн зардал өссөнтэй холбоотой.

#### 3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсөв захирагчийн 1 хөтөлбөрийн хүрээнд 2 арга хэмжээг улсын төсвөөс санхүүжүүлэхээр 550.8 сая төгрөгийн төсөв баталсан.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 550.8 сая төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 516.8 сая төгрөгийг зарцуулж 34.0 сая төгрөгийн улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 516.8 сая төгрөг буюу 94 хувьтай байгаа нь ажил олгогчоос цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал 28,1 сая төгрөгөөр, нийгмийн даатгалд төлөх шимтгэлийг 2.9 сая төгрөгөөр, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 0.9 сая

Говь-Алтай аймаг дахь ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

төгрөгөөр, хангамж, бараа материалын зардлыг 0.5 сая төгрөгөөр, томилолт зочны зардлыг 1.4 сая төгрөгөөр тус тус хэмнэж зарцуулсантай холбоотой.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансаар засаг даргын нөөц хөрөнгөөс 5.0 сая төгрөгийн орлого хүлээн авч оны эцэст татан төвлөрүүлэлт хийгээгүй. Нэмэлт санхүүжилтийн орлогыг хангамж, бараа материал, эд хогшил, урсгал засварын зардалд зарцуулжээ.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тодорхойлсон тодорхой бус байдал үүссэн, хэрэглэгчдэд хамааралтай санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудалгүй болно.

### 3.8 Аудитын гол асуудал

Тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудлууд байхгүй болно.

### 3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасны дагуу тус байгууллагын 2021 оны Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хяналаа.

### 3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд 2021 оны 834.8 сая төгрөгийн 37 мэдээллийг ил тод байршуулахаас 717.8 сая төгрөгийн 33 мэдээллийг ил тод байршуулж, 47.3 сая төгрөгийн 4 мэдээллийг мэдээлээгүй байсныг залруулсан.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ", "6.4.4.таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг", "6.4.5.цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр" гэсэн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

### 3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 2.3 сая төгрөгийн зөрчил арилгах албан шаардлага хүргүүлж бүрэн хэрэгжсэн.

Говь-Алтай аймаг дахь ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

### 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар бараа материалын дансны үлдэгдлийг тулган баталгаажуулалтыг үзэх нь зүйтэй.

Дараа жилийн аудитаар тушаал шийдвэртэй холбоотой зарцуулалт, тээвэр шатахууны зарцуулалтыг тулган баталгаажуулах эсэхийг үзэх нь зүйтэй.

Жилийн эцсийн хөрөнгийн тооллогоор 36.1 сая төгрөгийн газрыг орхигдуулан тоолсон нь тооллого комиссын гишүүд, тооцоо бодон хянасан нягтлан бодогчийн хариуцлагагүй байдалтай холбоотой тул дараагийн удаа зөрчлийг давтан гаргахгүй байхад анхаарах.

## 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 36.6 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 36.5 сая төгрөгийн алдааг залруулж, 0.1 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлсэн.

### 4.1 Залруулсан алдаа

Нэр бүхий 4 компаниас 7.8 сая төгрөгийн худалдан авалтын и-баримтыг гаргуулаагүй байсныг аудитын явцад нөхөж шивүүлсэн.

### 4.2 Төлбөрийн акт

Аудитаар төлбөрийн акт тогтоогоогүй.

### 4.3 Албан шаардлага

Санхүүгийн тайлан болон татварын тодорхойлолт 0.02 сая төгрөгөөр илүү, 0.1 сая төгрөгөөр дутуу зөрүү гарсан нь Төсвийн тухай хуулийн 6.4.8-т "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.5-т "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;", 20.2.6-т "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;" гэсэн заалттай нийцээгүй, оршин байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүллээ.

### 4.4 Зөвлөмж

Аудитаар зөвлөмж өгөөгүй.

## 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

| д/д | Аудитад хамрагдсан байгууллагын нэр | Нийт алдаа, зөрчлийн | | Үүнээс | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Залруулга | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| 1 | Говь-Алтай аймгийн Прокурорын газрын | 3 | 36.6 | 1 | 36.5 | 0 | 0 | 1 | 0.1 | 0 | 0 |

Говь-Алтай аймаг дахь ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР